



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2018.11.
2018.11.



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.


Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

2017 онд аймгийн хүн ам 87243 болж өмнөх оноос 2,2 хувиар буюу 1912 хүнээр нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд Хүрээмарал сумаас бусад сумын хүн ам өссөн байна. Нийт хүн амыг хүйсээр нь авч үзвэл 50.6 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Байршилаар авч үзвэл 33.8 хувь нь аймгийн төв, 11.9 хувь нь сумын төв, 52.6 хувь нь хөдөө, 1.6 хувь тосгонд байна.

2017 онд Баянхонгор аймаг 26270 өрхтэй болж өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсчээ. Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл 34.4 хувь нь аймгийн төвд, 12.1 хувь нь сумын төвд, 52.0 хувь нь хөдөөд, 1.5 хувь нь тосгонд байна.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2018 оны эхний 11 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 12709.5 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 3022.9 сая төгрөгөөр өссөн байна. 2018 оны 11 сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг БаянОвоо, Богд, Баянбулаг, Баянлиг, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан, сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ЦХТА орлого /суутган-1/ 377.7 сая төгрөг, ус ашигласны төлбөр 178.9 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 12.2 сая төгрөгөөр тус тус тасарч, ҮХЭХ борлуулсны татвар 26.3 сая төгрөг, хог хаягдлын хураамж 2.2 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 19.3 сая төгрөг, ИОТТХ 30.8 сая төгрөг, агаарын бохирдол /авто/ татвар 3.4 сая төгрөг, НӨАТатвар 449.2 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 238.9 сая төгрөг, орон нутгийн зам ашигласны хураамж 52.9 сая төгрөгөөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 3.6 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.2 хувь, ЦХТА орлого 33.2 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 3.3 хувь, хүү торгууль 7.0 хувь, бусад төлбөр хураамж 12.9 хувийг тус тус эзэлж байна



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2018 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар арилжааны банкуудаар 171343.7 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 11 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 169860.4 сая төгрөг байгаагийн 167207.8 сая төгрөг нь хэвийн зээл, 1706.1 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2429.8 сая нь чанаргүй зээл байна.

2018 оны эхний 11 сарын байдлаар иргэдийн хадгаламж 99568.9 сая төгрөг болжээ, үүний 23540.4 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 75939.0 сая төгрөг нь хугацаатай хадгаламж, 89.5 сая төгрөг нь бусад хадгаламж, сертификат байна.

Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 14559.8 сая төгрөг болжээ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс 11 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 1.2 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд голлож мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 6.0 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, согтууруулах ундаа, тамхиний бүлгийн барааний үнэ, тээврийн бүлгийн барааны үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 11 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 6.9 хувиар өссөн байгаа нь голлож тээврийн бүлгийн барааны үнэ, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ, боловсролын үйлчилгээний бүлгийн барааны үнэ, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

Баянхонгор аймгийн хэрэглээний үнийн индекс	2018.11/ 2017.11	2018.11/ 2017.12	2018.11/ 2018.10
ЕРӨНХИЙ ИНДЕКС	106.9	106.0	101.2
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	108.5	106.7	101.5
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	108.1	108.1	100.1
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	103.5	102.9	101.0
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	109.2	109.0	100.0
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	104.7	104.4	101.1
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	105.1	103.0	101.5
07. ТЭЭВЭР	113.1	112.5	102.4
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.6	102.4	100.0
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	106.8	106.8	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	107.4	107.4	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	110.0	95.2	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	101.2	100.3	101.3



АЖ ҮЙЛДВЭР

2018 оны 11 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 11335.7 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4565.9 сая төгрөгөөр буюу 67.4 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

Нийт борлуулалт	Арваннэгдүгээр сар		
	2017	2018	2018.11 / 2017.11
	6769706.0	11335694.0	167.4

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Арваннэгдүгээр сар		
		2017	2018	2018.11 /2017.11
Алт	Кг			
Нүүрс	Мян.тн	32.7	49.7	153.9
Нарийн боов	тн	119.5	138.7	116.1
Талх	тн	143.2	161.8	113.0
Хиам	тн	7.3	8.0	109.6
Дулаан	Мян.Гкал	227.6	419.5	184.3
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	357.7	625.4	174.8



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Баянхонгор аймгийн мал 2017 онд 4587738 болж өмнөх оноос 8.3 хувиар буюу 351417 толгойгоор өсчээ.

Аймгийн дүнгээр мал таван төрөл дээрээ өссөн байна. Нийт малыг сүргийн бүтцээр нь авч үзвэл адуу 3.9 хувь, үхэр 5.2 хувь, тэмээ 1.2 хувь, 30.1 хувь хонь, ямаа 59.5 хувийг тус тус эзэлж байна. Баяновоо, Богд сумаас бусад 18 сум малаа 1.4-18.0 хувиар өсгөсөн байна.

Улсын хэмжээнд манай аймаг нийт малын тоогоороо 5 дугаарт орж, ямаан сүргийн тоогоороо 1 дүгээрт, тэмээн сүргийн тоогоороо 2 дугаарт орж байна.

Аймгийн хэмжээнд 10 сарын 04-ны мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээр оны эхний хээлтэгчийн 36.5 хувь буюу нийт 666246 хээлтэгч төллөсөн ба гарсан төлийн 93.0 хувь буюу 619514 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 7012, унага 20372, тугал 47253, хурга 250218, ишиг 294659 толгой бойжсон байна.

Баянхонгор аймгийн 09 дүгээр сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр 306810 толгой мал үүнээс өвчнөөр 116, хээлтэгч 61668 толгой мал тус тус хорогдсон нь оны эхний нийт малын 6.7 хувийг эзлэж байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 288, адуу 5219, үхэр 9274, хонь 64735, ямаа 227294 толгой тус тус хорогджээ. Мөн нийт хорогдсон малын 20.1 хувь буюу 61668 толгой хээлтэгч мал хорогдсон байна.

Тариалсан талбайн 2018 оны 06 сарын мэдээгээр нийт 543.3 га д тариалалт хийсэн байна. Тариалсан талбайг төрлөөр нь задлаж харвал төмс 197.5 га, тэжээлийн ургамал 227.5 га, хүнсний ногоо 115.1 га д тус тус тариалжээ.

Тариалсан талбайг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 55.9 га буюу 22.1 хувиар, тэжээлийн ургамал 117.1 га буюу 33.9 хувиар, хүнсний ногоо 29.4 га буюу 20.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 1907.7 тонн төмс, 983.4 тонн хүнсний ногоо хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс 359.8 тонноор, хүнсний ногоо 189.1 тонноор тус тус өссөн байна. Нийт 13389.5 тн өвс бэлтгэсэн бол үүний 12404.8 тн өвсийг гаднаас худалдаж авсан байна, мөн 188.6 тн гар тэжээл бэлтгэжээ.



НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний 11 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 26384.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 5950.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1777.7 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 731.5 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 36.3 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 1014.9 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 379.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 63.9 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 18.6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 284.2 сая төгрөг тус тус олгожээ

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 11 сард 11022 хүнд 5624.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 2604 эхчүүдэд 391.2 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 7571 эхэд 1016.3 сая төгрөг, алдар цолтой 25 ахмадад 45.4 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 4280 хүнд 399.8 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 1031 хүнд 199.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



ЭРҮҮЛ МЭНД

2018 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1879 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 67 төрөлтөөр өссөн байна. Нийт төрсөн эхийн 90.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 9.7 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 9 сарын байдлаар 23 гарчээ.

Аймгийн хэмжээнд 11 сарын байдлаар нийт 1291 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 149.6 байгааг 2017 онтой (114.3) харьцуулахад 1.2 дахин нэмэгдэж, сүрьеэгийн 3

нас баралт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад амьсгалын замын тууралтат халдварт өвчин болон сүрьеэ нэмэгдсэн байгаа нь анхаарал татаж байна.

Тайлант оны эхний 11 сарын байдлаар нас баралтын 464 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 57 тохиолдлоор нэмэгдэж, нийт нас баралтын 20.4 хувь нь эмнэлэгт нас барснаас 23.1 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна. (2017 онд 29.2 хувь)

Эхний 11 сарын байдлаар хорт хавдрын 94 нас баралт, осол гэмтлийн 55 нас баралт бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад хорт хавдрын нас баралт нэмэгдэж, осол гэмтлийн шалтгаант нас баралт буурсан дүнтэй байна. Нийт 16126 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 20.1 хувийг алсын, 5.7 хувийг осол гэмтлийн дуудлага эзлэж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага 2018 тохиолдлоор нэмэгдэж, нийт дуудлагад эзлэх алсын болон осол гэмтлийн дуудлага буурсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

2018 оны эхний 11 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1080 болж өмнөх сараас 12.4 хувиар буурчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 626 буюу 57.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 79.1 хувь буюу 854 иргэн, 45 дээш насныхан 226 иргэн 20.9 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой иргэд 655 буюу 60.6 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой иргэд 143 буюу 13.3 хувь, дээд, магистр, докторын боловсролтой иргэд 282 буюу 26.1 хувийг тус тус эзлэж байна.

Эхний 11 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 798 иргэн үүнээс 388 эмэгтэй ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 73.1 хувь нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 337 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 56.7 хувь буюу 191 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 51, Боловсруулах үйлдвэрийн салбарт 107, Худалдааны салбарт 22, санхүүгийн болон даатгалд 1, төрийн удирдлага болон албан журмын нийгмийн хамгаалалд 35, боловсролд 33, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 22, бусад салбаруудад 1-6 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 11 сарын байдлаар нийт 1166 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалд 22, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 47, Хөдөө аж ахуйн салбарт 286, Барилгын салбарт 186, Боловсролын салбарт 93, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 189, уул уурхай олборлолтын салбарт 106, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 54, боловсруулах үйлдвэрлэлд 129, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 19, бусад салбаруудад 1-4 ажлын байрны захиалга иржээ.



ГЭМТ ХЭРЭГ

2018 оны эхний 11 сард аймгийн хэмжээнд нийт 540 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33 нэгжээр буюу 7.0 хувиар өссөн байна. Хэргийн илрүүлэлт 49.5 хувьтай байна. Хэргийн гаралт 8 сумд буурч, 12 суманд өссөн байна. Гэмт хэрэгт 352 хүн холбогдон шалгагдсан ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 487 иргэн хохирч 11 хүн нас барж, 166 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 1013.0 сая төгрөгийн хохирол учирснаас хохирол нөхөн төлүүлэлт 7.6 хувьтай байна.

Урьд оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах, малын хулгай ижил түвшинд, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 67.0 хувь, олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 85 хувиар, золгүй учрал 56 хувь, дээрэм 40 хувиар тус тус буурсан байна. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 56.0 хувь, тээврийн хэрэгслийн хулгай 61.0 хувь, залилан 1 дахин, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 100 хувиар тус тус өссөн байна.

Энэ хугацаанд 19521 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8430 нэгжээр буюу 76.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ердийн журмаар 17733 зөрчлийг 402123.1 мянган төгрөгөөр торгосон, 1128 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 268230.0 мянган төгрөгөөр торгосон, нийт 18861 зөрчлийг 670353.1 мянган төгрөгөөр торгосон байна. Үүнээс 503 зөрчлийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 62 нэгжээр буюу 14.0 хувиар өссөн, 379 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37 нэгжээр буюу 10.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**Хаяг: АЗДТГазар 303, 305 тоот
Холбоо барих утас: 70442081, 70442403
И мэйл хаяг: bayankhongor@nso.mn
Вэб сайт: www.nso.mn /сайтын Баянхонгор Статистикийн хэлтэс-Бюллетень/,
bayankhongor.gov.mn /сайтын Статистик мэдээ мэдээлэл/**